



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААННУУР СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 4/03

Гурван сайхан

Электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг
худалдан борлуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.2 дахь заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, 6.7.14 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны А/268 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосугай.

2. Өсвөр насын хүүхдүүдийн электрон тамхины хэрэглээ, хүний эрүүл мэнд, амь насанд зоул эрсдэл учруулах никотины дадал, тамхинд донтох явдлыг бууруулах түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор 21 нас хүрээгүй хүнд утаат тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулах Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хамтарсан баг, Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Ч.Энхмаа), ЖДҮ хариуцсан мэргэжилтэн (Т.Баасансүрэн), Цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Ч.Хосбаяр) нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилт гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Гэрэлт-Од)-д уурэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНСҮРЭН

672601017